








Химийн бодистой харьцахдаа пиктограмыг шалгана уу!

	Пиктограм	Голлох аюул эсвэл химийн аюул	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний голлох жишээ
Аюул	 (Тэсрэх бөмбөг)	Тэсрэлт: их хэмжээний тэсрэх аюул Тэсрэлт: гал түймэр, дэлбэрэлт, тэсрэх аюул Халах үеийн тэсрэх аюул	Тамхи татахыг хориглоно. Зөвхөн оригинал савлагаатай нь хадгална Өндөр температур, оч, дөлний эх үүсвэрээс хол байлгах. Гал гарсан тохиолдолд нүүлгэн шилжүүлэх. гал түймэртэй ТЭМЦЭЖ БОЛОХГҮЙ Гал тэсэрч дэлбэрэх бодист хүрэх үед Доторх бодис, савыг хуулийн дагуу устгана.
	 (Дөл)	Шатамхай хий эсвэл аэрозол Амархан асдаг шингэн эсвэл уур Шатамхай хатуу биет Халах үед гал гарах аюултай Агаарт ил гарах үед аяндаа шатах эрсдэлтэй Устай харилцан үйлчлэхэд шатамхай хий ялгаруулдаг	Дулаан, халсан гадаргуу, оч, ил гал болон бусад галын эх үүсвэрээс хол байлгах. Тамхи татахыг хориглоно. Агааржуулалт сайтай газар хадгална. Санал болгох нэмэлт зүйлс: АРСАНД ХҮРВЭЛ: Арьсан дээрх хэсгийг сойзоор угаах. Хүйтэн усанд дүрнэ. Зарим тохиолдолд уснаас зайлсхийх шаардлагатай тул энэ зөвлөмж эрсдэлтэй байж болно.
	 (Дөлний тойрог)	Галын эсвэл гал түймэр ихсэх аюул Гал гарах эсвэл тэсрэх аюул Гал түймэр ихсэх аюул	Дулаан, халсан гадаргуу, оч, ил гал болон бусад галын эх үүсвэрээс хол байлгах. Тамхи татахыг хориглоно. Шатах материалаас хол байлгах. Тусад нь хадгалах.
	 (Хийн баллон)	Даралтат хий: халах үед тэсрэх аюултай Хөргөсөн шингэн хий: хөлдөөх, мөсөөр түлэх аюултай	Нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалах. Агааржуулалт сайтай газар хадгалах. Хүйтнээс хамгаалах зориулалтын бээлий өмсөж, нүүрний эсвэл нүдний хамгаалалт ашиглах. Царцсан хэсгүүдийг бүлээн усаар гэсгээх. Нөлөөлд өртсөн хэсгийг үрж болохгүй. Яаралтай эмнэлгийн зөвлөгөө / тусламж авах.
	 (Зэврэлт)	Металлын идэмхий шинжтэй байж болзошгүй Арьсанд хүчтэй түлэгдэлт, нүдэнд гэмтэл үүсгэнэ.	Зөвхөн оригинал савлагаатай нь хадгална Арьс, нүдэнд хүргэхээс зайлсхийх. Хүрсэн тохиолдолд тухайн хэсгийг нэн даруй угаана Дараа нь бие болон өмсөж буй хувцсаа угаах. Хамгаалалтын хувцас, бээлий болон шил зүүх.
Эрүүл мэндэд үзүүлэх аюул	 (Гавал ба яс)	Амьсгалах, залгих эсвэл арьсанд хүрсэн үеийн цочмог хордлого (үхлийн эсвэл хортой).	Амьсгалж, амандаа эсвэл арьсандаа хүргэж болохгүй. Хүрсэн тохиолдолд яаралтай эмнэлгийн тусламж авах. Зөвхөн гадаа эсвэл агааржуулалт сайтай газарт ашиглах. Маск, хамгаалалтын хувцас болон хамгаалалтын бээлий өмсөх. Агуулахыг цоожтой байлгах.
	 (Эрүүл мэндэд үзүүлэх аюул)	Удамшлын эмгэг үүсэх аюултай. Хорт хавдар үүсгэх аюултай Нөхөн үржихүйд хортой эсвэл хүний урагт үзүүлэх гаж нөлөөтэй Амьсгалсан тохиолдолд харшил, астма, амьсгалахад хүндрэл учруулах аюултай Зарим эрхтэнд онцгой хортой Амьсгалын замаар орсон үеийн цочмог хордлого (аспираци)	Арьсанд бүү хүргэ. Амьсгалж болохгүй. Маск, хамгаалалтын бээлий болон хамгаалалтын хувцас өмсөх. Тухайн газрыг агааржуулах. Хэрэв ямар нэг хэвийн бус байдал ажиглагдах эсвэл өртсөн байх магадлалтай тохиолдолд эмчид хандах.
	 (Анхаарлын тэмдэг)	Цочмог хордлого. Амьсгалах, залгих эсвэл арьсанд хүрэхэд хортой Нүд ба арьсыг хүчтэй цочрооно Арьсны харшил үүсгэх аюултай Амьсгалын эрхтнийг цочроох, унтаарах, толгой эргэх аюултай	Амьсгалахаас зайлсхийх. Хэрэв таны бие мүү байвал эмчид хандана уу. Хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх.
	 (Байгаль орчин)	Усны амьд организмд маш хортой	Байгаль орчинд тархахаас сэргийлэх. Доторх бодис, савыг хуулийн дагуу устгах.
Байгаль орчны аюул		Агаар мандлын дээд давхарга дахь озоньг устгах замаар нийгмийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хордуулна	Цуглуулах, дахин боловсруулахтай холбоотой мэдээллийг үйлдвэрлэгч эсвэл ханган нийлүүлэгчтэй холбоо барьж авна уу.

Тэмдэглэл: Энд урьдчилан сэргийлэх арга хэмжээний гол жишээнүүдийг жагсаасан болно.